**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 03. 24 № 129

танай __________ -ны № __________ -т

ЦОГТ СУМЫН БАЯНТООРОЙ
ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
Б.БАЯРБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сумын Орон нутгийн төсвийн орлогыг 198,623.4 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 246,445.2 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 47,821.8 мянган төгрөгөөр буюу 124.0 хувьтай биелүүлсэн байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 485,357.8 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 41,187.3 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

8225020375

Тайлант онд 199,900.0 мянган төгрөгийн авто машиныг үндсэн хөрөнгөд үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

Аймгийн төсвөөс эко ариун цэврийн байгууламж барих 25,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 17.520.4 мянган төгрөгийг гүйцэтгэгчид урьдчилан шилжүүлж авлагаар тайлагнасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 7 зорилт 78 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 85.25 хувьтай үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2025/013/НА-СТА-ТТЗ


| | |
|---|---|
| | Дарга,Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа |
| | Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn |
| | Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг |
| Цахим хуудас: www.audit.mn | Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn |
| Алтай хот | Ахлах аудитор: Д.Цэрэнханд |
| 2025 он | Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn |
| | Аудитор: О.Энхтөр |
| | Утас: 95343496 Цахим хаяг: enkhturo@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 102,350.8 | 79,961.0 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 51,429.6 | 41,299.9 |
| 33 | АВЛАГА | 25,000.0 | 17,520.5 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 25,921.2 | 21,140.7 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 457,252.9 | 899,184.5 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 457,252.9 | 899,184.5 |
| 39200 | Биет хөрөнгө | 442,356.9 | 884,288.5 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 14,896.0 | 14,896.0 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 559,603.8 | 979,145.6 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 25,673.6 | 96.3 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 25,673.6 | 96.3 |
| 41300 | Өглөг | 25,673.6 | 96.3 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 533,930.1 | 979,049.2 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 533,930.1 | 979,049.2 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 44,633.0 | 44,633.0 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 258,885.2 | 704,004.3 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 230,411.9 | 230,411.9 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 559,603.8 | 979,145.6 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 710,837.2 | 1,202,547.0 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 147,929.5 | 254,089.6 |
| 110 | Орлогын албан татвар | 146,731.8 | 252,024.8 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 146,731.8 | 254,997.0 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | - | (2,972.2) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 997.7 | 1,614.8 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 200.0 | 450.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 22,985.0 | 504,286.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 22,985.0 | 504,286.9 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 539,922.7 | 444,170.5 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 690,134.3 | 757,427.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 690,134.3 | 757,427.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 350,817.5 | 754,937.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 114,841.8 | 175,250.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 15,069.3 | 22,480.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 96,983.2 | 430,470.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 23,938.6 | 34,493.1 |



ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативд зардал** | 793.6 | 360.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,493.5 | 17,456.6 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 792.0 | 986.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 29,275.2 | 1,014.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 56,630.2 | 72,426.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 339,316.9 | 2,490.0 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | 20,702.8 | 445,119.2 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | 20,702.8 | 445,119.2 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 513,227.3 | 513,227.3 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 513,227.3 | 513,227.3 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | 20,702.8 | 20,702.8 |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 533,930.1 | 533,930.1 |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 533,930.1 | 533,930.1 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 533,930.1 | 533,930.1 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 445,119.2 | 445,119.2 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | 979,049.2 | 979,049.2 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

*2043 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 716,037.2 | 699,946.6 |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 147,929.5 | 254,089.6 |
| **110** | **Орлогын албан татвар** | 146,731.8 | 252,024.8 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 148,551.3 | 254,997.0 |
| **1101** | **Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт** | (1,819.5) | (2,972.2) |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 997.7 | 1,614.8 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 200.0 | 450.0 |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | - | 250.0 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | 200.0 | 200.0 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 3,185.0 | 1,686.5 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,185.0 | 1,686.5 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 564,922.7 | 444,170.5 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 666,102.0 | 701,183.3 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 666,102.0 | 701,183.3 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 301,785.1 | 698,693.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 114,168.2 | 176,088.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 15,069.3 | 22,250.8 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,270.7 | 425,741.4 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,142.0 | 34,442.1 |
| **2105** | **Нормативт зардал** | 793.6 | 360.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,750.0 | 17,456.6 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 792.0 | 986.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 121,536.8 | 18,502.7 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,262.6 | 2,865.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 364,316.9 | 2,490.0 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | 49,935.2 | (1,236.7) |
| V | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 27,139.8 | 8,893.0 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 27,139.8 | 8,893.0 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 27,139.8 | 8,893.0 |
| VI | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | (27,139.8) | (8,893.0) |
| VIII | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | 22,795.4 | (10,129.7) |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 28,634.3 | 51,429.6 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 51,429.6 | 41,299.9 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **701,649.8** | **692,587.7** | **579,147.3** | **98.7** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **701,649.8** | **692,587.7** | **579,147.3** | **98.7** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **699,149.8** | **690,097.7** | **576,657.3** | **98.7** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 178,000.0 | 176,088.7 | 176,088.7 | 98.9 |
| 210101 | Үндсэн цалин | 114,000.0 | 116,113.0 | 116,113.0 | 101.9 |
| 210102 | Нэмэгдэл | 50,400.0 | 51,152.6 | 51,152.6 | 101.5 |
| 210104 | Урамшуулал | 13,600.0 | 8,823.1 | 8,823.1 | 64.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,250.8 | 22,250.8 | 22,250.8 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,610.8 | 15,610.8 | 15,610.8 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,660.0 | 1,660.0 | 1,660.0 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 830.0 | 830.0 | 830.0 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 830.0 | 830.0 | 830.0 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,320.0 | 3,320.0 | 3,320.0 | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 428,601.0 | 425,741.4 | 314,301.0 | 99.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,982.0 | 14,498.9 | 14,498.9 | 96.8 |
| 210302 | Түлш, халаалт | 413,619.0 | 411,242.5 | 411,242.5 | 99.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 34,443.0 | 34,442.1 | 34,442.1 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 1,200.0 | 1,200.0 | 1,200.0 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,500.0 | 30,499.2 | 30,499.2 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 600.0 | 599.9 | 599.9 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 583.0 | 583.0 | 583.0 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,560.0 | 1,560.0 | 1,560.0 | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 360.0 | 360.0 | 360.0 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 360.0 | 360.0 | 360.0 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 29,500.0 | 26,349.6 | 24,349.6 | 89.3 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11,500.0 | 8,498.0 | 8,498.0 | 73.9 |
| 210602 | Тавилга | 500.0 | 395.0 | 395.0 | 79.0 |
| 210604 | Урсгал засвар | 17,500.0 | 17,456.6 | 17,456.6 | 99.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,200.0 | 986.0 | 986.0 | 82.2 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,200.0 | 986.0 | 986.0 | 82.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,095.0 | 1,014.1 | 1,014.1 | 92.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 900.0 | 900.0 | 900.0 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 125.0 | 47.7 | 47.7 | 38.1 |
| 210807 | Газрын төлбөр | 70.0 | 66.4 | 66.4 | 94.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,700.0 | 2,865.0 | 2,865.0 | 77.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,700.0 | 2,865.0 | 2,865.0 | 77.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,500.0 | 2,490.0 | 2,490.0 | 99.6 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,500.0 | 2,490.0 | 2,490.0 | 99.6 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,500.0 | 2,490.0 | 2,490.0 | 99.6 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **701,649.8** | **692,587.7** | **588,449.4** | **98.7** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **701,649.8** | **692,347.7** | **0.0** | **98.7** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 701,649.8 | 692,347.7 | 0.0 | 98.7 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **17,488.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **17,488.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **17,488.6** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **17,488.6** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,488.6 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **25,000.0** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **25,000.0** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,000.0 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 7,511.4 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**3.1** Аудитаар нийт 710.9 сая төгрөгийн 1 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна.

Залруулсан алдаа

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- Мөнгөн гүйлгээний тайланд 711.0 сая төгрөгийн устгах бичилт хийгдээгүй НЬ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

## 3.2 Албан шаардлага

1 Захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Захирагчийн албаны санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 9.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** (мянган төгрөг)

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн нэгтгэсэн тайлан | 1 | 710,951.8 | - | - | 1 | 710,951.8 | 1 | 710,951.8 | - | - | - | - |
| Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын алба | 3 | 10,203.3 | 2 | 7,607.7 | 1 | 2,595.6 | 3 | 10,203.3 | - | - | - | - |
| **Дүн** | **4** | **721,155.1** | **2** | 7,607.7 | **2** | **713,547.4** | **4** | **721,155.1** | - | - | - | - |

**6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** **(мянган төгрөг)**

| Байгууллагын нэр | Бүгд | Өөрчлөлттэй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзах | Түүвэрт | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн нэгтгэсэн тайлан | 1 | 1 | - | - | - | - | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - |
| Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын алба | 1 | 1 | - | - | - | - | 3 | 26,936.6 | 1 | 950.0 | 1 | 8,498.0 | 1 | 17,488.6 | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **2** | **-** | **-** | **-** | **-** | **4** | **26,936.6** | **1** | **950.0** | **2** | **8,498.0** | **1** | **17,488.6** | **-** | **-** | **-** | **-** |

**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** **(мянган төгрөг)**

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цогт сумын Баянтоорой тосгоны Захирагчийн ажлын алба | 2 | 25,986.6 | - | - | 1 | 8,498.0 | 1 | 17,488.6 |
| **Дүн** | **2** | 25,986.6 | **-** | **-** | **1** | 8,498.0 | **1** | 17,488.6 |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР